



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/28

Мөрөн сум

**“Тоглоомын талбайн засвар тохижилт”-ын
ажлын явцад хяналт тавих, хүлээн авах
комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2026 оны 01 сарын 26-ны өдрийн А/13 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2026 оны 03 сарын 02-ны өдрийн 01 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. “Кэй Эл Си Си” ХХК нь сумын ОНХ сангийн хөрөнгө оруулалтаар “Тоглоомын талбайн засвар, тохижилт”-ын ажлын тендерт ялж 2026 оны 04 сарын 15-наас 2026 оны 07 сарын 01-ний дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Б. Баасандорж	Цагаан толгой багийн Засаг дарга
Гишүүдэд: Ө.Өнөрөө	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
Г.Дашмаа	Төрийн сангийн мэргэжилтэн
Г.Энхцэцэг	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан
А.Энхтөр	Аж ахуйн нярав

2. “Кэй Эл Си Си” ХХК -аас хүлээн авах “Тоглоомын талбайн засвар, тохижилт”-ын ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн өнгө үзэмж, тоо ширхэг, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Б.Баасандорж)-д үүрэг болгосугай.

3. “Тоглоомын талбайн засвар, тохижилт”-ын ажлын явцад гарсан хуучин эд хогшил, тоног төхөөрөмжүүдийг акт үйлдэн, тоолж хүлээж авахын Засаг даргын Тамгын газрын аж ахуйн нярав (А.Энхтөр)-д даалгасугай.

4.Шинэ тоглоомын талбайг хөрөнгөнд бүртгэж хувийн хэрэгт баяжилт хийх, хуучин эд хогшил, тоног төхөөрөмжүүдийг цаашид яаж ашиглах талаар санал боловсруулж танилцуулахыг нягтлан бодогч (Т.Баяртуяа), Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Ц.Болорцэцэг)-нэрт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ